# ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АДЪЯАСҮРЭНГИЙН ЦЭРЭНЧИМЭДИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: “Нийгмийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, арга зүйгээр хангах, тайлагнах” | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, тэтгэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай хууль, Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын талаар иргэдэд мэдээлэл өгөх | Сургалт мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо | | 50 | Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, тэтгэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай хууль, дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журамд зааснаар 4 оюутаны материалыг бүрдүүлж холбогдох сургуулиудад нь хүргэж ажилласан. Хүний эрхэд суурилсан хандлага сургалт хэлэлцүүлгийг хүний эрхийн комиссын гишүүн, доктор, дэд профессор Б.Энхболдоор ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Төрийн албан хаагч, иргэдэд “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалт зохион байгуулж 310 төрийн албан хаагч иргэд, Улсын өмгөөлөгчтэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар сургалт мэдээлэл хүргэж “Иргэдээ сонсоё” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 230 гаруй иргэдийг хамруулж нийт 4 | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээний хүрээнд 574 иргэнийг хамруууллаа. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Салбарын үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж тайлан мэдээ гаргаж ажиллах | Тайлан мэдээний тоо | 4 | 1 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж хяналтандаа авч тайлан мэдээг хугацаанд нь гарган ажиллаж байна. | 01.02-12.25 | 100 |
| 3. | **Дэд арга хэмжээ 1.2.1** Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Тайлан мэдээний тоо | 2 | 1 | Сургуулийн хүүхдийн үдийн хоолны хүнсгий хангамжид хэрэглэх түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу зохион байгуулан "УБЦНЗ" ХХК, "Машид дэлгэрэх" ХХК, "Сүүн шим", "Батхангай АТС" ХХК, Гучингийн хөсөг ХХК, БНБТС ХХК аж ахуй нэгжүүдийг шалгаруулан нийлүүлж байна. Сурагчдын өдөрт авах илчлэгийг нарийн тооцож, хоолны жор бэлтгэх технологийг сургуулийн эмч, тогооч, нар 7 хоногоор гаргаж сургуулийн захирлаар баталгаажуулан өдөр бүр халуун хоолоор үйлчилж байна. 2025 оны байдлаар Ерөнхий сургуулийн 1-5 дугаар ангийн 1372 сурагч хамрагдаж, хичээлийн 5 өдөрт халуун хоолоор үйлчлүүлж хэвшсэн. Хүнсний аюулгүй байдлын Хяналт шалгалтын хүрээнд Ерөнхий боловсролын 4 дотуур, 5 цэцэрлэгийн гал тогоонд хяналт шалгалт хийсэн. | 01.02-12.25 | 100 |
| **Зорилт 2. " Боловсрол, хүн ам, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудлаар хөтөлбөр, төсөл боловсруулах, төлөвлөх, зохицуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангах, тайлагнах"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ2.1** Сурагчдын санал, санаачилгыг дэмжин сургууль дээр үйл | Хамрагдсан хүүхдүүдийн тоо | 1120 | 200 | Өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар олгох арга зүйн сургалтад ерөнхий боловсролын 3 | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаа явуулж буй Сурагчийн зөвлөл болон дугуйлангуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх | | | | сургуулийн 2 багш, 88 сурагч шинээр хамрагдлаа.<br>2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 4 сургууль, Соёлын төв, Спортын ордонд 99 дугуйлан, клуб хичээллэж давхардсан тоогоор 2529 сурагч хамрагдаж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байна. "Сонголт-Миний ирээдүй" уриан дор хүүхдийн чуулга уулзалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн 150 хүүхэд, Боловсролын сайдын эрүүл мэндийн боловсрол хариуцсан зөвлөх О.Цэцэгбал болон Бор аварга сантай хамтран 9-12 дугаар ангийн сурагчдад Өсвөр насны эрүүл мэнд, сайн сайхан байдал сэдвүүдээр сургалт орж, Монгол мөрөөдөл эссэ бичлэгийн уралдаан, Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан 16 насанд хүрч буй 66 сурагчаар иргэний андгай өргүүлж, иргэний үнэмлэхийг гардуулан өглөө. Хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан Монгол бичгийн олимпиадыг 7-12 дугаар анги, насанд хүрэгчид гэсэн 2 төрлөөр зохион байгуулж 225 сурагч, 35 насанд хүрэгчид нийт 260 иргэн, Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан "Эрх чөлөөний үнэ цэн" эссэ бичлэгийн уралдааныг 10-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 35 сурагч, Өсвөрийн аврагч-2025 аймгийн аврага шалгаруулах тэмцээнд 8-12 дугаар ангийн 12 хүүхдийн бүрэлдэхүүнтэй 1 багийг бэлтгэн оролцуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ 2.2** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо | 3 | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, АНУ төвтэй Холд Интернэшнл ТББ-тай хамтран Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр-ийн хамт олонтой хамтарч байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хоол үйлдвэрлэгч нарт хоол тэжээлийн талаар сургалтыг зохион байгуулж 23 иргэн хамрагдсан. | 01.02-12.25 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 2.3** Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Аз жаргалтай гэр бүл" арга хэмжээ зохион байгуулж, залуучуудын хамрагдалтыг нэмэгдүүлэх | Арга хэмжээнд хамрагдсан гэр бүлийн тоо | - | 5 | "Халуун ам бүл" төслийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Аз жаргалтай гэр бүл" вакум сургалтыг зохион байгуулж, 10 гэр бүлийн 20 иргэнийг хамрууллаа.<br><br>Гэр бүлийн харилцаа, харилцан хүндлэл, хүүхэд хүмүүжлийн арга барил, зөрэг харилцааг төлөвшүүлэх чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.<br><br>Сургалтад 1,65 сая төгрөг зарцууллаа. | 01.02-12.25 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 2.4** Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зан үйл, амьдралын эрүүл зан үйл, зөв дадал хэвшилд сургаж, иргэд олон нийтийн хандлагыг өөрчлөх арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | - | 50 | Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Эрчүүдэд тулгамдаж буй асуудал", Гэр бүл салалт", "Харилцаа ба хандлага", "Гэр бүлийн тухай" сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж, 218 залуучууд хамрагдлаа. Насан туршийн суралцахуйн нэгжтэй хамтран Цэргийн насны залуучуудын дунд "Эрүүл чийрэг эр хүн" сэдэвт 2 удаагийн сургалтад 75 залуу, "Мэргэжил сонголт", "Харилцаа хандлага", "Эх | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ороңч үзэл" сэдэвт сургалтад ахлах ангийн 200 гаруй сурагчид тус тус хамрагдлаа. Электрон тамхины сөрөг нөлөөл таниулах, түүний хэрэглээг бууруулах чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулиуд, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч Д.Чулуунбат нартай хамтран сургалт зохион байгуулж 350 гаруй сурагчдыг хамруулаа. Нийт 840 хөвгүүд эрэгтэйчүүдийг хамруулаад байна. | | |
| 5 | **Арга хэмжээ 2.4**<br>Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэхижүүлж, бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах. | Хэрэгжилтийн хувь | - | 45 | Засаг даргын А/235 дугаар захирамжаар "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн зөвлөл" байгуулагдаж, 22 хэрэгжүүлэх арга хэмжээтэй төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж , 95 хувийн биелэлттэй байна.<br>"Бага насны хүүхдийн цогц хөгжил" сэдэвт сургалтад 5 бүлгийн 24 эцэг эх, 6 багш, 1,4,5 дугаар цэцэрлэгийн арга зүйч нарын зохион байгуулсан "Бага насны хүүхдийн цогц хөгжил" сэдэвт сургалтад 1 арга зүйч, 6 багш, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан Ногоон гэрэл-цагаан шугам арга хэмжээнд 50 хүүхэд тус тус оролцсон,<br>Соёлын төв, Хархорум музейтэй хамтран зохион байгуулсан "ГЭР БҮЛИЙН УНШЛАГА"-д 15 гэр бүл оролцлоо. Спортын ордонтой хамтран цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд хөдөлгөөнт гимнастик, хөгжөөнт буухиа тэмцээн зохион байгуулж, 210 хүүхэд оролцож, 600,000 төгрөг зарцууллаа.<br>Бага насны хүүхдийн асаргаа, хөгжил боловсролын үйлчилгээ үзүүлдэг 200 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.<br>Нярайн эрт үеийн түнхний ЭХО шинжилгээг 10 сарын байдлаар 221 нярайг оношилсон | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. Хүүхдийн дунд зонхилон тохиолдож байгаа ахуйн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, анхны тусламж, хоол тэжээл зэрэг сэдвээр 100 гаруй нэр төрлийн видео контент, зурагт хуудас бэлтгэн Хархорин нэгдсэн эмнэлэг фэйсбүүк цахим хаягаар иргэд олон нийтэд мэдээлж, 5160 удаагийн хандалт авсан.<br>:Зөв гэр" бүл сэдвээр 300 гаруй иргэнд сургалт хийж, -Ахуйн орчин дахь осол, гэмтлээс сэргийлэе -Болгоомжтой алхаарай -Шим тэжээллэг хүнс хэрэглэж дархлаагаа дэмжицгээе -Цахим орчин дахь танихгүй хүний аюул -Эрүүл зөв хооллолт -Хүүхдийн биед шаардлагатай витаминуудын тухай -Хүүхэд-аюулгүй орчин -Хариуцлагатай аав ээжийн энгийн дүрэм -Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлье зэрэг 270 ширхэг брошур мэдээллийг бэлтгэж эцэг, эхчүүдэд хүргэсэн.<br>Нярай болон 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжил, хоол тэжээлийн хяналтыг сайжруулж, 1409 хүүхдэд гэрийн болон амбулаторийн сувилахуйн тусламж үзүүлэв.<br>2025 оны 09 дүгээр сарын байдлаар Нэгдсэн эмнэлэгт 135 эх амаржиж, эх болон нярайг товлолт хугацаанд эргэж, эхийн сүүгээр хооллох ач холбогдол, нярай болон эхэд илрэх аюултай шинж, хүйн арчилгаа, шарлалтыг ажиглах, гэр бүл төлөвлөх, өөрийгөө асрах зөвлөмжийн талаар 18 удаагийн сургалт, зөвлөмжийг эргэлтийн явцад өгсөн. Нийт 8 төрлийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж 6027 иргэн, 2040 хүүхэд хамрагдаж, 1,600,000 төгрөг зарцууллаа. | | |
| **Зорилт 3. "Суманд үйл ажиллагаа явуулж буй нийгмийн салбар байгууллагуудын ажлыг уялдуулах, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах"** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Арга хэмжээний тоо | 1 | 2 | Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан "Нар шиг гэрэлтэх жаалууд" хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулж алба хаагч нарын 143 хүүхдэд хүүхдийн баярын бэлэг гардуулан эцэг эхээр нь сэтгэлийн үгтэй захидалын хамт хүргүүлсэн. "Аз жаргалтай гэр бүл" вакум сургалтад Засаг даргын Тамгын газрын 2 гэр бүлийн төлөөллийг оролцууллаа. | 01.02-12.25 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж залуучууд, залуу гэр бүлд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Залуучуудын хөгжлийн салбарын зөвлөлийг шинэчлэн 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан Сумын хэмжээнд ганц бие 522 залуучуудын судалгааг гарган Өвөрхангай аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. Хархорин Марафон-2025, Эрүүл монгол үндэсний хөдөлгөөний хүрээнд Засаг даргын Тамгын газар, Спортын ордонтой хамтран 2025.01.30-2025.05.29-ний өдрийн хооронд Өглөөний гүйлтийг зохион байгуулж давхардсан тоогоор 680 гаруй иргэд хамрагдсан ба түүнээс 20 гаруй хувь буюу 140 гаруй залуучууд хамрагдсан байна. 2025.03.15-ны өдөр Өвөрхангай аймгийн Байгаль орчны газар, Орон нутгийн өмчит Хархорин-Ус суваг ХХК, Засаг даргын Тамгын газар хамтарч ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан байгаль орчны багц сургалтыг зохион байгуулж ахлах ангийн 150 гаруй сурагч хамрагдаж байгаль орчны талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүллээ. "Аз жаргалтай гэр бүл" вакум сургалтыг зохион байгуулж, 10 гэр бүлийн 20 иргэнийг хамруулж, Гэмт хэргээс урьдчилан | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх салбар зөвлөлөөс 1,65 сая төгрөг зарцууллаа. 3 арга хэмжээний хүрээнд нийт 850 иргэдийг хамруулаад байна. | | |
| **Зорилт 4. "Нийгмийн зорилтот бүлгүүд, хүн ам, өрхийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг орон нутгийн бодлого боловсруулахад тусгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 4.1.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтийг хангах тайлагнах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гарган Монгол Улс, Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, Өвөрхангай аймаг, Франц Улсын Аллиер мужтай найрсаг харилцаа тогтоосны 25 жилийн ойн арга хэмжээний ажлын хүрээнд Франц Улсын Аллиер мужаас 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж Ерөнхий эмч Жан Клод Дэспрэ, нийгмийн ажилтан Нэлли Дэлма нар "Ахмад настны эрүүл мэнд ба ахмадын онцлог" сэдвээр Хархорин Нэгдсэн эмнэлэг, Энэрэл-Хархорин ӨЭМТ-ийн эмч, ажилчдад сургалт зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, АНУ төвтэй Холд Интернэшнл ТББ-тай хамтран Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр-ийн хамт олонтой хамтарч байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хоол үйлдвэрлэгч нарт хоол тэжээлийн талаар сургалтыг 2025.06.06-ны өдөр зохион байгуулж 23 иргэн хамрагдсан. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Б.Чулуундолгортой хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба Нийгмийн загвар" сургалтын зохион байгуулж 58 иргэнийг хамрууллаа. Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдрийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрлөгийг жил | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Энэ жил Насан туршийн боловсролын арга зүйч, Улсын өмгөөлөгчтэй хамтран 30 гаруй иргэн хууль, эрх зүй болон хувь хүнд чиглэсэн сургалтыг зохион байгууллаа.<br>4 арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 111 иргэнийг хамруулаад байна. | | |
| 2. | **Арга хэмжээ 4.2.**<br>Залуучуудын судалгааг нас, хүйсээр нь нарийвчлан гаргаж тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтийг хангах тайлагнах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2 | Сумын хэмжээнд 15-34 насны 3420 хүний судалгааг гаргаж тэдгээрт чиглэсэн Монгол Улс, Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, Өвөрхангай аймаг, Франц Улсын Аллиер мужтай найрсаг харилцаа тогтоосны 25 жилийн ойн арга хэмжээний ажлын хүрээнд Франц Улсын Аллиер мужаас 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж 2025.04.24-2025.05.03-ны хооронд ажиллаж сэтгэл судлаач, сексологич Алинэ Дупик "Ажлын байран дээрх халшрах хам шинж" буюу "BURN OUT" сэдвээр сургалт зохион байгуулж 200 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа. "Хархорин марафон-2025" арга хэмжээг 5 төрөлд, 9 ангиллаар зохион явууллаа. Арга хэмжээнд 15 байгууллагын 275, Баян-Өлзий, Булган, Эрдэнэт, Улаанбаатар хотын 29 тамирчин тус тус оролцсон. Хангайн бүсийн залуучуудын чуулга уулзалтыг Монголын залуучуудын холбоотой хамтран зохион байгуулж Архангай, Өвөрхангай, Баянхонгорын 150 гаруй залуучууд оролцлоо. Миний нутаг сайхан урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулж 152 аж ахуй нэгжийн 660 гаруй ажилтан, албан хаагчид оролцлоо,<br>4 арга хэмжээний хүрээнд нийт 1314 иргэнийг хамруулсан. | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Арга хэмжээ 4.3**<br>“Халуун ам бүл” төслийг хэрэгжүүлэх | Төслийн хэрэгжилтийн хувь | - | 25 | “Халуун ам бүл” төслийн хүрээнд хөтөлбөрийн хувийн хэргийг нээн Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг зохион байгуулж, нийт 7 байгууллагын 99 албан хаагчид Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын бодлого болон Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг танилцуулан, хэрэгжилтийг хангах зөвлөмж өгч ажиллалаа. Мөн Халуун ам контентын уралдаанд нэг гэр бүлийг оролцуулсан байна.<br>“Хүүхэд хамгаалал ба кейс менежмент” сэдэвт сургалтад хамтарсан багийн 15 гишүүн, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийгмийн ажилтан, арга зүйч, сэтгэлзүйчийг чадавхжуулах сургалтад 13 албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулсан. Халуун ам бүл контентийн уралдаанд 1 гэр бүлийн видёо бичлэгийг хүргүүлэн ажилласан. | 01.02-12.25 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 4.4**<br>“Хайрлагдсан хүүхэд” төслийг хэрэгжүүлнэ. | Төсөлд хамрагдсан хүүхдийн тоо | - | 5 | “Хайрлагдсан хүүхэд” төслийн хүрээнд “Зөв таниас эхлэнэ” хүүхдийн чуулганд Ерөнхий боловсролын сургуулийн 9–12 дугаар ангийн 12 сурагчийг хамруулж, Засаг даргын Тамгын газраас 500,0 мянган төгрөг зарцуулсан. Зорилтод өрхийн 13 хүүхдийг “Цагаан залаа” төвд, Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын 13 хүүхдийг “Найрамдал” хүүхдийн зусланд амрааж хөгжлийн үйлчилгээ үзүүлсэн. Өсвөр насны хүүхдийн эрхийн хөндөгдсөн болон зөрчигдсөн асуудлын талаар “Хуулийн цаг” подкастыг Хууль эрх зүйн мэргэжилтэн, Улсын өмгөөлөгч Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан нар бэлтгэж олон нийтэд түгээсэн. “Хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн 9–12 дугаар ангийн 80 сурагчийг хамруулан шийдвэр | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаргагчид уламжилсан. "Зөв дадал–Эрүүл ирээдүй" сэдэвт хүүхдийг хорт зуршил, архи, согтууруулах ундаа, утаат болон электрон тамхи, мансууруулах бодис хэрэглээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах сургалтад 65 иргэнийг хамруулж мэдээлэл, зөвлөмж өгсөн. | | |
| 5 | **Арга хэмжээ 4.5** Электрон тамхины хэрэглээг бууруулах чиглэлээр "Ирээдүйгээ бүү сор" аян арга хэмжээг зохион байгуулна. | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 20 | Сумын хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхэлдэг 35 аж ахуй нэгж байгууллагаар хяналт шалгалт хийж насанд хүрээгүй хүнд электрон тамхи худалдан борлуулахгүй байх талаар "Ирээдүйгээ бүү сор" уриалга гаргаж уриалгыг дэмжсэн гарын үсэг цуглуулах, мэдээллийн самбаруудад хэвлэмэл зурагт хуудасыг байршуулсан. Электрон тамхины сөрөг нөлөөг таниулах, түүний хэрэглээг бууруулах талаар нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн их эмч Д.Чулуунбат болон Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран сургалт зохион байгуулж 350 - гаруй сурагчид хамруулсан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" арга хэмжээний хүрээнд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран "Тамхигүй ирээдүй" сэдэвт контентын уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн 9–12 дугаар ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулагдаж 4 сургуулийн 8 бүтээл оролцлоо. | 01.02-12.25 | 100 |
| **Зорилт 5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 5.1** ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, | Гүйцэтгэлийн төлөвлөгөөн | 85 | 80-100 | ТАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг гарган ажиллаж байна. | 01.02-12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх; | ий хэрэгжилтийн хувь | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Нийгмийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, арга зүйгээр хангах, тайлагнах"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Албан тушаал, мэргэжил, арга зүйн чиглэлийн сургалт, семинарт оролцох, практик туршлагаа нэмэгдүүлэх | Хамрагдсан сургалт арга хэмжээний тоо | - | 2 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас Галт шувуу ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хүүхэд хамгаалал ба кейс менежмент" сэдэвт сургалт 2025.05.05-2025.05.07-ны сургалтанд хамрагдаж Батламж авсан. "Хүний эрхэд суурилсан хандлага" уулзалт хэлэлцүүлэгт, "Ажлын байрны дарамт, халшрах хам шинж", "Төрийн албан хаагчийн ёс зүй", Өөрийгөө хайрлах нь, Хиймэл оюун ухаан AI технологийг ажлын байранд хэрхэн ашиглах талаар цахим сургалтуудад тус тус хамрагдсан. | 01.02-12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2 | | | | Монгол Улс, Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, Өвөрхангай аймаг, Франц Улсын Аллиер мужтай найрсаг харилцаа тогтоосны 25 жилийн ойн арга хэмжээний ажлын хүрээнд Франц Улсын Аллиер мужаас 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж 2025.04.24-2025.05.03-ны хооронд тусгай хэрэгцээт хүүхдүүдэд үзлэг, сэтгэл зүйчийн зөвлөгөө,, эцэг эх, асран хамгаалагч нарт хөдөлгөөн заслын сургалт, зөвлөгөө,, сэтгэл судлаач, сексологич Алинэ Дупик "Ажлын байран дээрх халшрах хам шинж" буюу "BURN OUT" сэдвээр сургалт зохион байгуулж 200 гаруй төрийн албан хаагч хамрагдаж түүний хүрээнд сургалт зохион байгуулах байр бэлтгэх, үйл явцын зураг авах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | | 100 |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3 | | | | Тусгаар тогтнол-3333 аяны хүрээнд Улаанбаатар хотын Оюуны ундраа сургуулийн 34 багш сурагчдын бүрэлдэхүүнтэй баг ирж Орхон сургуультай туршлага солилцон 104 хүүхэд Эрдэнэ зуу хийдийн гадна талбайд “Туснаар тогтнол” шүлгийг улс орон даяар нэгэн зэрэг уншсан. Үүний хүрээнд сурагчдыг хүлээж авах | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байрлуулах болон арга хэмжээ зохион байгуулж ажилласан. | | |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4 | | | | Замын хөдөлгөөний цагаан толгой арга хэмжээг Сум дундын цагдаагийн хэлтэс болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж 4 цэцэрлэгийн 50 хүүхэд багчууд оролцсон. Шүүгчийн үүрэг болон үйл ажиллагааны зураг дарах гүйцэтгэсэн. | | 100 |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5 | | | | Засаг даргын Тамгын газрын 43 албан хаагчаас ажилтаны сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн үр дүнг танилцуулсан. | | 100 |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6 | | | | Хүнсний аюулгүй байдлын Хяналт шалгалтын ажлын хэсэгт орж 4 сургууль, 3 дотуур байр, 5 цэцэрлэг, худалдаа үйлчилгээ эрхэлдэг 35 хүнсний худалдаа эрхлэч байгууллагуудаар орж хяналт шалгалт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хугацаа дууссан зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээ авсан. | | 100 |
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7 | | | | Өрхийн амжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажлын хэсэгт орж Ганган орхон, Эрдэнэтолгой багуудын айл | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өрхүүдээр орж судалгааг авч нэгтгэн програмд оруулсан. | | |
| 8 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8 | | | | Хөгшин. Орхон голын ай сав газрын хамгаалалтын бүс дэх хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2025.05.08-ны өдөр зохион байгуулагдаж алба хаагчидтай хог цэвэрлэсэн. Туркийн зам дагуух тариен талбайн хашаа болон зам дагасан хог хаягдлыг цэвэрлэсэн. | | 100 |
| 9 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9 | | | | Бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын алба хаагчид хүүхдийн парк болон Мойлтын аманд мод тарилт хийсэн. | | |
| 10 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10 | | | | Өвөрхангай аймгийн хэлний бодлогын зөвлөл, насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан монгол бичгийн сорилыг Хархорин сумын Сум дундын шүүхийн тамгын газрынг алба хаагч нараас авсан. | | 100 |
| 11 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 11 | | | | Хангай хайрханы тахилга зохион байгуулах ажлын хэсэгт орж Хурдан морины уралдаанч хүүхдийг бүртгэх, хүүхэд хамгаалал талаас хүүхдийн эдлэл хэрэглэл биеийн эрүүл мэндэд хяналт тавьж давхардсан тоогоор 48 унаач хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьсан. | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 12 | | | | Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбоотойгоор архивын баримт бичгийг цэгцэлсэн. | | 100 |
| 13 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 13 | | | | Наадамын нээлтийн үйл ажиллагааны хүндэтгэлийн жагсаалд төрийн 35 байгууллагыг оролцуулан зохион байгууллаа. | | 100 |
| 14 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 14 | | | | 2 дугаар ээлжийн Цэрэг татлагатай холбогдуулан Эрдэнэтолгой багт ажилж цэргийн насны залуучуутай холбогдо, зарлан дуудах хуудас тараах болон цэрэг татлагт бүртгэл хийж ажилласан. | | 100 |
| 15 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 15 | | | | Хэлний бодлогын зөвлөлөөс төрийн 8 байгууллагаар явж албан хэрэг хөтлөлтөд хос бичигтэн арга хэмжээг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | | 100 |
| 16 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 16 | | | | Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 187 хүүхдийг хамрууллаа. | | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Нийгмийн бодлогын мэргэжилтэн А.Цэрэнчимэд / .......................... / 2025 ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ 1.2.**<br>Төрийн албаны цахим хуудасны бодлогын инновац цэсэд байршуулсан вебинар сургалт, мэдээллийг бие даан судлах | Бие даан судалсан сургалт, мэдээллийн тоо | 6 | 3 | 7:4:10 цахим вебинар сургалтууд болон Удирдлагын академын Монгол бичгийн сургалтад хамрагдсан. Солонгос хэлний анхан шатны сургалтад хамрагдсан. | 01.02-12.25 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 1.3**<br>Монгол бичгийн уншиж, бичих чадвараа сайжруулна. | Монгол бичгийн чадварын хувь | 20 | 30 | Монгол бичгийн цахим сургалтад хамрагдаж түвшингээ ахиулан суралцаж байна. | 01.02-12.25 | 100 |

**Гурав: Нэмэлт үүрэг даалгавар арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1 | | | | Цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажлын хэсэгт орж ажиллан сумын 2025 оны 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэний судалгааг нэгтгэсэн. 2025 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажилд байр танхим засах, бэлтгэл хангах, Эрдэнэ толгой багийн Цэргийн насны иргэдэд зарлан дуудах хуудас тараах, анкет бүртгэл хөтлөх, үйл явцын зураг авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | | 100 |